



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2022.05.12 № 926
танай _____-ны № _____-т

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬД
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
Б.ИЧИННОРОВ

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын нөхөн сонгуульд бие даан нэр дэвшигч иргэн Батчулууны Ичинноровын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нөхөн сонгуульд бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөртөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулсан Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, нийслэлийн 2022-2023 оны төсвийн төсөөлөл, “Алсын хараа 2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Иргэн Батчулууны Ичинноровын дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-

002020687

2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Иргэн Батчулууны Ичинноровын сонгуулийн мөрийн хөтөлбөр /... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг Багахангай дүүргийн Сонгуулийн хороонд

Хавсралт: 2 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН 2022 ОНЫ НӨХӨН СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
Б.ИЧИННОРОВЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Монгол улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал, тулгуур зарчмыг үндэс болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулсан сонгуулийн мөрийн хөтөлбөрөө сонгогч танд танилцуулж байна.

1. Иргэдэд үзүүлэх үйлчилгээний нэр төрөл, чанар хүртээмжийг улам сайжруулж, иргэдийг үнэн бодитой мэдээ мэдээлэл, тоо баримтаар хангана.

2. Хороонд хийгдэх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын төлөвлөлт, шийдвэрт иргэд өөрсдөө оролцож Иргэдийн оролцоот төлөвлөлт, хэрэгжилтийг нэвтрүүлнэ.

3. Харьяалагдах нутаг дэвсгэрийн байгалийн баялаг, ан амьтан, хадлан, бэлчээрийн талбайн ашиглалт, хамгаалалтад холбогдох байгууллага, малчид, иргэдийн оролцоотойгоор эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавьж, зүй зохистой ашиглаж, нөхөн сэргээлт хийлгэх шаардлагатай газруудыг холбогдох байгууллагуудад уламжилна.


4. Гэр хороололд амьдарч байгаа айл өрхүүдийн орчин нөхцөлийг сайжруулж био жорлон нэвтрүүлэн хөрсний бохирдлыг багасгах, сайжруулсан шахмал түлшний хэрэглээг нэвтрүүлэхэд хамтран ажиллана.

5. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр иргэн, аж ахуйн нэгжүүдээс гаргасан санал, санаачилгыг дэмжин хамтран ажиллана.

6. Иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд харшлахгүй, ажлын байр бий болгох төсөл хөтөлбөр, хувийн хэвшлийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж, хамтарч ажиллана.

7. Мэргэжлийн холбоодтой хамтран уралдаан, тэмцээн зохион байгуулах, дүүргээ сурталчлах үйл ажиллагааг онцгойлон дэмжинэ.

8. Дүүрэг, хороог эдийн засаг, нийгмийн цогцолбор, засаг захиргааны нэгжийн хувьд аймаг, сум, багтай адилтган шийдвэр гаргаж ирсэн практикийг өөрчлөх санал, санаачилга гаргаж шийдвэр гаргах түвшинд хүргэн ажиллана.



Б.ИЧ

9. Иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хүрээнд шийдвэрлүүлэх, тэдний гаргасан санал санаачилгыг дэмжин олон нийтийн ажил, арга хэмжээг зохион байгуулан ажиллана.

МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН:



Б.ИЧИННОРОВ

